# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

## 2018 оны 10 дугаар сар

**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24%-иар буюу 2,101 сая ам.доллараар өсч 10,820 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 15%-иар буюу 756 сая ам.доллараар, импорт 38%-иар буюу 1,345 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 589 сая ам.доллараар буурч 1,069 сая ам.долларын ашигтай байна.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | Жилээр | | | Өөрчлөлт | | | | Эхний 10 сар | | | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2015 | 2016 | 2017 | 2016/2015 | | 2017/2016 | | 2016 | 2017 | 2018 | 2017/2016 | | 2018/2017 | |
| | | | | Дүн | Хувь | Дүн | Хувь | | | | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Эргэлт** | **8,467** | **8,274** | **10,536** | **(192)** | **-2%** | **2,262** | **27%** | **6,494** | **8,719** | **10,820** | **2,225** | **34%** | **2,101** | **24%** |
| Экспорт | 4,669 | 4,916 | 6,201 | 247 | 5% | 1,284 | 26% | 3,726 | 5,189 | 5,945 | 1,463 | 39% | 756 | 15% |
| Импорт | 3,798 | 3,358 | 4,335 | (439) | -12% | 977 | 29% | 2,768 | 3,530 | 4,876 | 762 | 28% | 1,345 | 38% |
| **Тэнцэл** | **872** | **1,558** | **1,865** | **686** | | **307** | **20%** | **957** | **1,659** | **1,069** | **701** | **73%** | **(589)** | **-36%** |

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл**** 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 437 сая ам.доллараар буурч 1,367 сая ам.долларын ашигтай гарсан байна.

**Зураг 1.** Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




**Зураг 2.** Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар




**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 66% буюу 7,158 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14% буюу 1,464 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 37%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 29%-иар тус тус өссөн байна.

**Зураг 3.** Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/




**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15%-иар, өмнөх сараас 0.1%-иар өсч 1.939-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх оны мөн үеэс сайжирахад чулуун нүүрс, зэсийн экспортын үнийн өсөлт голлон нөлөөлөв.

**Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.*

*** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.*

# Экспорт



**Экспорт** 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 15%-иар буюу 756 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 13 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурсан байна.

**Хүснэгт 3.** Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2016 | | | 2017 | | | 2018 | | | Δ (2017/2016) | | | Δ (2018/2017) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **1. Уул уурхай** | | **3,169** | **85%** | | **4,592** | **88%** | | **5,267** | **89%** | **1,423** | **45%** | **38%** | **675** | **15%** | **13.0%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 1,321 | 1,393 | 37% | 1,204 | 1,302 | 25% | 1,205 | 1,669 | 28% | (91) | -7% | -2% | 367 | 28% | 7% |
| 1.2. Чулуун нүүрс | 18,557 | 605 | 16% | 28,143 | 1,911 | 37% | 30,941 | 2,439 | 41% | 1,306 | 216% | 35% | 528 | 28% | 10% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | 6,564 | 269 | 7% | 6,308 | 306 | 6% | 4,968 | 327 | 5% | 38 | 14% | 1% | 20 | 7% | 0% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 5,332 | 209 | 6% | 5,030 | 261 | 5% | 6,048 | 274 | 5% | 51 | 24% | 1% | 14 | 5% | 0% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 10,955 | 445 | 12% | 12,589 | 515 | 10% | 3,432 | 144 | 2% | 70 | 16% | 2% | (370) | -72% | -7% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 106 | 117 | 3% | 101 | 151 | 3% | 103 | 167 | 3% | 34 | 29% | 1% | 16 | 11% | 0% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 207 | 50 | 1% | 245 | 63 | 1% | 422 | 141 | 2% | 13 | 26% | 0% | 77 | 122% | 1% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 4 | 20 | 1% | 6 | 32 | 1% | 5 | 40 | 1% | 12 | 60% | 0% | 9 | 27% | 0% |
| 1.9. Гянтболдын хүдэр, баяжмал | 1 | 9 | 0% | 1 | 7 | 0% | 1 | 6 | 0% | (2) | -25% | 0% | (1) | 0% | 0% |
| 1.10. Мөнгө /тонн/ | 79 | 34 | 1% | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | (33) | -98% | -1% | (0) | 0% | 0% |
| 1.11. Бусад | 75 | 17 | 0% | 307 | 44 | 1% | 434 | 58 | 1% | 27 | 20x | 1% | 15 | 34% | 0% |
| **2. Мал аж, ахуй** | 160 | **270** | **7%** | 291 | **336** | **6%** | 326 | **420** | **7%** | **66** | **24%** | **2%** | **83** | **25%** | **1.6%** |
| 2.1. Амьд мал, малын мах | 5 | 12 | 0% | 19 | 36 | 1% | 26 | 59 | 1% | 25 | 212% | 1% | 23 | 63% | 0% |
| 2.2. Арьс, шир | 134 | 19 | 1% | 248 | 19 | 0% | 275 | 13 | 0% | (1) | -3% | 0% | (5) | -28% | 0% |
| 2.3. Малын өлөн гэдэс | 0 | 5 | 0% | 0 | 5 | 0% | 0 | 7 | 0% | 0 | 5% | 0% | 2 | 0% | 0% |
| 2.4. Ноолуур | 6 | 214 | 6% | 7 | 251 | 5% | 8 | 313 | 5% | 37 | 17% | 1% | 61 | 24% | 1% |
| 2.5. Ноос, бусад үс, хялгас | 14 | 19 | 1% | 15 | 23 | 0% | 13 | 25 | 0% | 4 | 19% | 0% | 2 | 8% | 0% |
| 2.6. Бусад | 0 | 1 | 0% | 1 | 2 | 0% | 3 | 3 | 0% | 1 | 65% | 0% | 1 | 34% | 0% |
| **3. Газар тариалан** | 116 | **16** | **0%** | 148 | **12** | **0%** | 34 | **7** | **0%** | **(4)** | **-25%** | **0%** | **(4)** | **-36%** | **-0.1%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | 223 | **270** | **7%** | 350 | **248** | **5%** | 191 | **250** | **4%** | **(22)** | **-8%** | **-1%** | **2** | **1%** | **0.0%** |
| 4.1. Хүнс | 5 | 27 | 1% | 16 | 68 | 1% | 20 | 57 | 1% | 41 | 151% | 1% | (11) | -16% | 0% |
| 4.2. Ноолууран эдлэл | 1 | 21 | 1% | 1 | 27 | 1% | 1 | 30 | 1% | 6 | 29% | 0% | 3 | 11% | 0% |
| 4.3. Бусад хувцас, гутал, эдлэл | 1 | 11 | 0% | 2 | 13 | 0% | 3 | 21 | 0% | 2 | 13% | 0% | 8 | 63% | 0% |
| 4.4. Уул уурхай | 25 | 70 | 2% | 30 | 93 | 2% | 46 | 90 | 2% | 23 | 32% | 1% | (2) | -2% | 0% |
| 4.5. Цахилгаан, электрон бараа | 0 | 4 | 0% | 0 | 1 | 0% | 0 | 3 | 0% | (4) | -81% | 0% | 2 | 215% | 0% |
| 4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги | 1 | 129 | 3% | 1 | 41 | 1% | 3 | 45 | 1% | (88) | -68% | -2% | 4 | 10% | 0% |
| 4.7. Бусад | 190 | 7 | 0% | 300 | 6 | 0% | 118 | 4 | 0% | (1) | -18% | 0% | (2) | -29% | 0% |
| **5. Бусад** | 1 | **1** | **0%** | 1 | **1** | **0%** | 1 | **1** | **0%** | **0** | **4%** | **0%** | **0** | **8%** | **0.0%** |
| **Нийт дүн** | | **3,726** | | | **5,189** | | | **5,945** | | **1,463** | **39%** | | **756** | **15%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 4.** Экспортын өөрчлөлт, 2018 оны 10 дугаар сар

| Төрөл | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Уул уурхай** | **(135)** | | **810** | | **675** | **15%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 1 | 0% | 365 | 100% | 367 | 28% |
| 1.2. Чулуун нүүрс | 221 | 42% | 307 | 58% | 528 | 28% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | (88) | -431% | 109 | 531% | 20 | 7% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 46 | | (32) | | 14 | 5% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | (386) | 104% | 15 | -4% | (370) | -72% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 3 | 19% | 13 | 81% | 16 | 11% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 59 | 76% | 18 | 24% | 77 | 122% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | (5) | -64% | 14 | 164% | 9 | 27% |
| 1.11. Бусад | 17 | 116% | (2) | -16% | 15 | 34% |
| **2. Мал аж, ахуй** | **65** | | **18** | | **83** | **25%** |
| 2.1. Амьд мал, малын мах | 16 | 70% | 7 | 30% | 23 | 63% |
| 2.2. Арьс, шир | 1 | -26% | (6) | 126% | (5) | -28% |
| 2.3. Малын өлөн гэдэс | 1 | 81% | 0 | 19% | 2 | 0% |
| 2.4. Ноолуур | 48 | 78% | 14 | 22% | 61 | 24% |
| **3. Газар тариалан** | **(25)** | | **21** | | **(4)** | **-36%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | **60** | | **(58)** | | **2** | **1%** |
| **5. Бусад** | **(1)** | | **1** | | **0** | **8%** |
| **Нийт дүн** | **(36)** | | **792** | | **756** | **15%** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2018 оны эхний 10 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 36 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 792 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 222 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 672 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 60 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 58 сая ам.доллараар буурсан байна.

**Зураг 4.** Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ




Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 10 дугаар сард 1,215 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5%-иар буурсан хэдий ч өнгөрсөн сараас 1.4%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,220; 73 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 8%-иар буурсан, харин төмрийн хүдэр 19%-иар өссөн бол өнгөрсөн сараас зэс 2.8%-иар, төмрийн хүдэр 7.3%-иар өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 10 дугаар сард 81 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 13%-иар, өмнөх сараас 0.3%-иар өссөн байна.

**Импорт** 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 38%-иар буюу 1,345 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 19 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг бүрдүүлж байна.

**Хүснэгт 5.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2016 | | | 2017 | | | 2018 | | | Δ (2017/2016) | | | Δ (2018/2017) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | | **956** | **35%** | | **1,050** | **30%** | | **1,340** | **27%** | **94** | **10%** | **3%** | **291** | **28%** | **8%** |
| Түргэн эдэлгээтэй | 688 | 522 | 19% | 697 | 594 | 17% | 805 | 705 | 14% | 72 | 14% | 3% | 112 | 19% | 3% |
| *Хүнс* | *321* | 360 | *13%* | *316* | 412 | *12%* | *383* | 488 | *10%* | *52* | *14%* | *2%* | *76* | *19%* | *2%* |
| *Эм, тариа* | *2* | 74 | *3%* | *2* | 77 | *2%* | *2* | 98 | *2%* | *3* | *4%* | *0%* | *20* | *26%* | *1%* |
| *Бусад түргэн эдэлгээтэй бараа* | *365* | 87 | *3%* | *378* | 105 | *3%* | *419* | 120 | *2%* | *17* | *20%* | *1%* | *15* | *14%* | *0%* |
| Удаан эдэлгээтэй | 108 | 434 | 16% | *179* | 456 | 13% | *197* | 635 | 13% | 22 | 5% | *1%* | 179 | 39% | *5%* |
| *Гутал, хувцас, цүнх* | *39* | 43 | *2%* | *58* | 51 | *1%* | *49* | 61 | *1%* | *8* | *19%* | *0%* | *10* | *19%* | *0%* |
| *Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга* | *21* | 80 | *3%* | *66* | 73 | *2%* | *80* | 95 | *2%* | *(7)* | *-9%* | *0%* | *21* | *29%* | *1%* |
| *Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл* | *1* | 261 | *9%* | *1* | 277 | *8%* | *1* | 411 | *8%* | *16* | *6%* | *1%* | *134* | *48%* | *4%* |
| *Бусад удаан эдэлгээтэй бараа* | *48* | 50 | *2%* | *54* | 55 | *2%* | *67* | 69 | *1%* | *5* | *9%* | *0%* | *14* | *26%* | *0%* |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | *947* | **981** | **35%** | *927* | **1,358** | **38%** | *1,236* | **2,015** | **41%** | **376** | **38%** | **14%** | **657** | **48%** | **19%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анги | 13 | 574 | 21% | 22 | 846 | 24% | 27 | 1,263 | 26% | 272 | 47% | 10% | 417 | 49% | 12% |
| *Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги* | 1 | 197 | *7%* | 1 | 247 | *7%* | 1 | 378 | *8%* | *50* | *26%* | *2%* | *131* | *53%* | *4%* |
| *Машин механик, тоног төхөөрөмж, эд анги* | 12 | 377 | *14%* | 22 | 599 | *17%* | 26 | 884 | *18%* | *221* | *59%* | *8%* | *286* | *48%* | *8%* |
| Барилгын материал | 638 | 250 | 9% | 542 | 370 | 10% | 691 | 572 | 12% | 120 | 48% | 4% | 202 | 55% | 6% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | 46 | 157 | 6% | 52 | 142 | 4% | 37 | 180 | 4% | (15) | -10% | -1% | 38 | 27% | 1% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | 817 | **426** | **15%** | 1,171 | **454** | **13%** | 1,306 | **608** | **12%** | **27** | **6%** | **1%** | **155** | **34%** | **4%** |
| Хүнсний орц | 185 | 51 | 2% | 35 | 16 | 0% | 273 | 75 | 2% | (34) | -68% | -1% | 59 | 358% | 2% |
| Химийн бүтээгдэхүүн | 98 | 68 | 2% | 155 | 89 | 3% | 167 | 101 | 2% | 21 | 31% | 1% | 12 | 13% | 0% |
| Даавуу, утас, арьс, савхин эдлэл | 21 | 15 | 1% | 38 | 18 | 1% | 66 | 25 | 1% | 3 | 19% | 0% | 7 | 37% | 0% |
| Цахилгаан эрчим хүч | 1 | 102 | 4% | 2 | 111 | 3% | 1 | 118 | 2% | 10 | 10% | 0% | 7 | 6% | 0% |
| Металлын хүдэр, баяжмал болон хаягдал | 1 | 1 | 0% | 1 | 1 | 0% | 0 | 1 | 0% | (1) | -57% | 0% | (0) | -7% | 0% |
| Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай | 640 | 190 | 7% | 695 | 218 | 6% | 729 | 289 | 6% | 28 | 15% | 1% | 71 | 33% | 2% |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **817** | **401** | **14%** | **1,171** | **663** | **19%** | **1,306** | **906** | **19%** | **263** | **66%** | **9%** | **243** | **37%** | **7%** |
| Дизель түлш | 413 | 184 | 7% | 676 | 351 | 10% | 694 | 460 | 9% | 167 | 90% | 6% | 109 | 31% | 3% |
| АИ-92, АИ-95 | 264 | 129 | 5% | 313 | 185 | 5% | 297 | 211 | 4% | 56 | 43% | 2% | 26 | 14% | 1% |
| А-80 болон бусад | 140 | 87 | 3% | 183 | 128 | 4% | 314 | 236 | 5% | 40 | 46% | 1% | 108 | 84% | 3% |
| **Бусад** | **9** | **5** | **0%** | **13** | **6** | **0%** | **260** | **6** | **0%** | **1** | **30%** | **0%** | **(0)** | **-6%** | **0%** |
| **Нийт дүн** | | **2,768** | | | **3,530** | | | **4,876** | | **762** | **28%** | | **1,345** | **38%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6.** Импортын өөрчлөлт, 2018 он

| Төрөл* | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | **167** | **57%** | **124** | **43%** | **291** | **28%** |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | **343** | **52%** | **314** | **48%** | **657** | **48%** |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | **65** | **42%** | **90** | **58%** | **155** | **34%** |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **100** | **41%** | **143** | **59%** | **243** | **37%** |
| Дизель түлш | 12 | 11% | 97 | 89% | 109 | 31% |
| АИ-92, АИ-95 | (11) | -42% | 37 | 142% | 26 | 14% |
| А-80 болон бусад | 99 | 91% | 9 | 9% | 108 | 84% |
| **Бусад** | **5** | | **(6)** | | **(0)** | **-6%** |
| **Нийт дүн** | **680** | **51%** | **665** | **49%** | **1,345** | **38%** |

** Ижил зориулалттай болович харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 657 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 291 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 243 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 155 сая ам.доллараар тус тус өссөнөөр нийт импорт 1,345 сая ам.доллараар өссөн байна.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/




Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 23 хувиар, өмнөх сараас 8 хувиар өсч тонн тутамд 760 ам.долларт хүрэв.